

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/191/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа

Утас: 92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Аудитор Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

обдд.од.16 № 130д/48

танай _____ -ны № _____ -т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, АХМАД
Л.БААСАНСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

013022917

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	56,716.63	58,715.26
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	91.50	179.60
312	Банканд байгаа бэлэн мөнгө	91.50	179.60
31210	Төгрөг	91.50	179.60
31211	Төрийн сангийн харилцах	91.50	179.60
35	БАРАА МАТЕРИАЛ	56,625.13	58,535.66
35100	Түүхий эд материал	13,608.48	26,642.87
35110	Тусгай зориулалттай материал	13,006.65	24,057.30
35130	Эм,боох материал	601.83	2,585.57
35300	Бэлэн бүтээгдэхүүн	4,562.98	3,999.49
35400	Хангамжийн материал	35,508.68	24,618.29
35410	Бичиг хэргийн материал	33.00	86.00
35420	Аж ахуйн материал	18,078.47	13,363.90
35430	Сэлбэг хэрэгсэл	3,415.00	180.00
35440	Түлш,шатах тослох материал	1,241.80	1,829.70
35450	Барилгын засварын материал	185.45	1,732.44
35460	Хүнсний материал	4,743.20	2,858.77
35470	Бусад хангамжийн материал	7,811.75	4,567.49
35600	Мал амьтад	2,945.00	3,275.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	916,145.37	866,462.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	916,145.37	866,462.79
392	Биет хөрөнгө	815,382.37	765,961.33
39201	Барилга,байгууламж,орон сууц	874,077.82	869,562.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	148,709.32	173,663.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,720.00	132,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	106,290.47	123,210.47
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	98,655.67	80,381.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	56,428.53	41,033.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,904.89	51,935.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	29,526.51	34,709.87
39211	Батлан хамгаалах,цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3,978.82	3,978.82
39300	Биет бус хөрөнгө	100,763.00	100,501.46
39301	Программ хангамж	7,484.71	6,665.76
39302	Хуримтлагдсан элэгдэл	7,223.17	6,665.76
39303	Бусад биет бус хөрөнгө	100,501.46	100,501.46
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	972,861.99	925,178.05
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	91.50	179.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	91.50	179.60
41300	Өглөг	91.50	179.60
41360	Бусад өглөг	91.50	179.60
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	91.50	179.60
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	972,770.49	924,998.45

51	Засгийн газрын хувь оролцоо	972,770.49	924,998.45
51101	Засгийн газрын оруулсан капитал	204,130.35	204,130.35
51200	Хуримтлагдсан үр дүн	756,622.68	709,040.29
51210	Өмнөх үеийн үр дүн	756,622.68	756,812.33
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-47,772.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	12,017.46	11,827.81
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	972,861.99	925,178.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	645,414.05	680,833.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,128.65	32,030.91
120	Нийтлэг татварын бус орлого	14,128.65	32,030.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,128.65	32,030.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,467.70	3,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,660.95	28,930.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,285.40	648,802.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	631,285.40	637,116.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	631,285.40	637,116.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	11,686.78
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	7,686.78
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	697,286.04	727,509.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	697,286.04	727,509.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	696,569.37	718,197.64
21.0	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	470,657.73	476,671.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	460,758.45	465,763.19
210101	Үндсэн цалин	275,427.30	308,888.06
210102	Нэмэгдэл	180,831.15	154,857.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,000.00	1,152.00
210104	Урамшуулал	1,500.00	866.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,899.28	10,908.57
210205	Эрүүл мэндийн даатгал	9,899.28	10,908.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,667.70	101,541.80
210301	Гэрэл, цахилгаан	9,567.70	9,046.00
210302	Түлш, халаалт	81,700.00	82,364.80
210303	Цэвэр, бохир ус	8,400.00	10,131.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,597.25	24,993.35
210401	Бичиг хэрэг	2,612.20	3,179.63
210402	Тээвэр, шатахуун	15,583.56	14,507.28
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530.90	1,712.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	178.70	154.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,015.25	1,516.05
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,376.72	899.65
210408	Бараа материал акталсны зардал	16,299.92	3,023.64
2105	Нормативд зардал	28,326.07	26,439.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,086.30	962.97
210502	Хоол, хүнс	24,848.95	23,983.89
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,390.83	1,492.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,596.25	8,686.82
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	433.36

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	145.00	178.40
210604	Урсгал засвар	5,451.25	8,075.06
2107	Томиллолт, зочны зардал	355.20	106.00
210702	Дотоод албан томиллолт	355.20	106.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,058.70	7,941.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,931.00	5,525.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432.00	368.90
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	370.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177.50	116.70
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110.00	110.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,245.10	1,269.00
210807	Газрын төлбөр	163.10	181.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,310.47	71,817.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,097.85	991.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	211.50	138.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,001.12	70,688.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	716.67	9,311.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	288.00	210.00
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	288.00	210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410.00	9,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410.00	9,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18.67	1.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18.67	1.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-51,871.99	-46,675.79
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,096.25
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	1,096.25
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-51,871.99	-47,772.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,090.00	-328.00	328.00	20,090.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-51,871.99	-51,871.99
2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	204,130.35	12,017.46	756,622.68	972,770.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	-189.65	189.65	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-47,772.05	-47,772.05
2021 оны 12 сарын 31-р үлдэгдэл	204,130.35	11,827.81	709,040.29	924,998.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	637,133.20	653,154.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,847.80	4,351.80
120	Нийтлэг татварын бус орлого	5,847.80	4,351.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,847.80	4,251.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,847.80	4,251.80
120009	Бусад орлого	0.00	100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	631,285.40	648,802.78
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	631,285.40	637,116.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	631,285.40	637,116.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	11,686.78
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	7,686.78
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,631.40	649,931.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,631.40	649,931.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,914.73	640,619.74
21.0	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	470,657.73	476,671.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	460,758.45	465,763.19
210101	Үндсэн цалин	275,427.30	308,888.06
210102	Нэмэгдэл	180,831.15	154,857.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,000.00	1,152,000.00
210104	Урамшуулал	1,500.00	866.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,899.28	10,908.57
210205	Эрүүл мэндийн даатгал	9,899.28	10,908.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,667.70	101,541.80
210301	Гэрэл, цахилгаан	9,567.70	9,046.00
210302	Түлш, халаалт	81,700.00	82,364.80
210303	Цэвэр, бохир ус	8,400.00	10,131.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,576.50	21,594.98
210401	Бичиг хэрэг	2,324.90	2,559.80
210402	Тээвэр, шатахуун	15,451.00	15,778.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530.90	1,712.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	178.70	154.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,091.00	1,389.90
2105	Нормативд зардал	24,953.40	22,249.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	705.20	724.50
210502	Хоол, хүнс	24,248.20	21,525.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,967.50	8,365.10
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	1,565.10
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	178.40	178.40
210604	Урсгал засвар	6,789.10	6,621.60
2107	Томилолт, зочны зардал	355.20	106.00
210702	Дотоод албан томилолт	355.20	106.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,466.00	9,064.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,338.30	6,648.70

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432.00	368.90
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	370.20
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177.50	116.70
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110.00	110.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,245.10	1,269.00
210807	Газрын төлбөр	163.10	181.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,270.70	1,025.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,059.20	842.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	211.50	183.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	716.67	9,311.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	288.00	210.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	288.00	210.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410.00	9,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410.00	9,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18.67	1.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18.67	1.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,501.80	3,223.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,497.00	3,134.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,497.00	3,134.90
2200	Дотоод эх үүсвэрээр	3,497.00	3,134.90
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,497.00	3,134.90
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,497.00	-3,134.90
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4.80	88.10
9	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	86.70	91.50
10	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	91.50	179.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	640,216.00	640,214.16	1.84	100
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	640,216.00	640,214.16	1.84	100
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	639,106.00	639,104.16	1.84	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	162,432.40	162,432.40	0.00	100
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	465,763.90	465,763.19	0.71	100
210101	Үндсэн цалин	299,958.80	308,888.06	8,929.26	103
210102	Нэмэгдэл цалин	163,787.10	154,857.14	8,929.96	95
210103	Унаа хоолны нэмэгдэл	1,152.00	1,152.00	0.00	100
210104	Урамшуулал	866.00	866.00	0.00	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,909.70	10,908.57	1.13	100
210205	Эрүүл мэндийн даатгал	10,909.70	10,908.57	1.13	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,541.80	101,541.80	0.00	100
210301	Гэрэл, цахилгаан	9,046.00	9,046.00	0.00	100
210302	Түлш, халаалт	82,364.80	82,364.80	0.00	100
210303	Цэвэр, бохир ус	10,131.00	10,131.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	20,120.70	20,120.70	0.00	100
210401	Бичиг хэрэг	2,559.80	2,559.80	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	14,303.90	14,303.90	0.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,712.20	1,712.20	0.00	100
210405	Хог, хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	154.90	154.90	0.00	100
210406	БҮТЭЗүйлс	1,389.90	1,389.90	0.00	100
2105	Нормативд зардал	22,249.60	22,249.60	0.00	100
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	724.50	724.50	0.00	100
210502	Хоол хүнс	21,525.10	21,525.10	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,500.00	10,500.00	0.00	100
210601	Багаж, техник хэрэгсэл	3,700.00	3,700.00	0.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	178.40	178.40	0.00	100
210604	Урсгал засвар	6,621.60	6,621.60	0.00	100
2107	Томилолт, зочны зардал	106.00	106.00	0.00	100
210702	Дотоод албан томилолт	106.00	106.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,888.40	6,888.40	0.00	100
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,472.50	4,472.50	0.00	100
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	368.90	368.90	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	370.20	370.20	0.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	116.70	116.70	0.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110.00	110.00	0.00	100

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,269.00	1,269.00	0.00	100
210807	Газрын төлбөр	181.10	181.10	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,025.90	1,025.90	0.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	842.60	842.60	0.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	183.30	183.30	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,110.00	1,110.00	0.00	100
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	210.00	210.00	0.00	100
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	210.00	210.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	900.00	900.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	900.00	900.00	0.00	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	640,216.00	640,214.16	1.84	100
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	3,100.00	3,100.00	0.00	100
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	637,116.00	637,114.16	1.84	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	637,116.00	637,114.16	1,840.83	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,686.78	11,686.78	0.00	100
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	11,686.78	11,686.78	0.00	100
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,486.78	3,486.78	0.00	100
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,486.78	3,486.78	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	1,474.28	1,474.28	0.00	100
210402	Тээвэр, шатахуун	1,474.28	1,474.28	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000.00	1,000.00	0.00	100
210601	Багаж, техник хэрэгсэл	1,000.00	1,000.00	0.00	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,012.50	1,012.50	0.00	100
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,012.50	1,012.50	0.00	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,200.00	8,200.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,200.00	8,200.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,200.00	8,200.00	0.00	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,686.78	11,686.78	0.00	100
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,686.78	11,686.78	0.00	100
131104	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,686.78	11,686.78	0.00	100

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсүвд, ахлах аудитор Б.Дагвасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Г.Заяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2021 онд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлж, албаны бэлэн байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын

дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт зардлаас 653.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 7.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах	91.5	179.6	88.1
Бараа материал	56,625.1	58,535.7	1,910.6
Үндсэн хөрөнгө	916,145.4	866,462.8	-49,682.6
Нийт хөрөнгө	972,862.0	925,178.1	-47,683.9
Өр төлбөр	91.5	179.6	88.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	972,770.5	924,998.5	-47,772.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	972,862.0	925,178.1	-47,683.9

Бараа материалын дансны үлдэгдэл 1,910.5 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал 13,034.4 мянган төгрөгөөр, мал амьтад 330.0 мянган төгрөгөөр өсөж, бэлэн бүтээгдэхүүн 563.5 мянган төгрөгөөр, хангамжийн материал 10,890.4 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 49,682.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 88.1 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүмүүст төлөх өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 47,772.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 640,216.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 640,216.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 637,116.0 мянган төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 3,100.0 мянган төгрөгийн, нийт 640,216.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 639,104.2 мянган төгрөгийг зарцуулж, 1.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 7,686.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 4,000.0 мянган төгрөгийн, нийт 11,686.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогоос 3,486.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 8,200.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь зардлын эдийн засгийн ангиллыг гүйлгэн зарцуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна” гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 956.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 433.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 523.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулгад 433.4 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 523.1 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангиллыг гүйлгэн зарцуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	2	956.5	1	433.4					1	523.1

